**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СНАГ-2024/342/НА-СТА-ТШ3**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2024 он | Санхүү нийцлийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Энхдалай<br>Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Долгоржав<br>Утас: 261628 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn<br>Аудитор: Э.Булганчимэг<br>Утас: 261628 Цахим хаяг: bulganchimege@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.23 № 07/358

танай ____________ -ны № ____________ -т

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГА Ц.БАТЗУЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Төрийн худалдан авах ажиллагааны газар нь Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай зохион байгуулж, төрийн худалдан авах ажиллагааг олон улсын жишигт хүргэх, нийгмийн суурь үйлчилгээг нийтэд үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 34 дүгээр тушаалаар 3 газар, 2 хэлтэс, 1 албатайгаар үйл ажиллагаа явуулахаар бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийгдсэн байна.

**Аудитын гол асуудал**

Төрийн худалдан авах ажиллагааны газар 2023 онд 2,008,917.2 тэрбум төгрөгийн 172 төсөл, арга хэмжээний 322 багцын тендер шалгаруулалт, ерөнхий гэрээгээр худалдан авах 15 төсөл, арга хэмжээний тендерийн 215 нэр төрлийн бараа, үйлчилгээ худалдан авах 681 ерөнхий гэрээг 253 нийлүүлэгчтэй, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 36,928.5 тэрбум төгрөгийн 70 төсөл, арга хэмжээний 154 багц, он дамжин хэрэгжих 432,339.3 тэрбум төгрөгийн 51 төсөл, арга хэмжээний 80 багц

нийт 469,267.8 тэрбум төгрөгийн 121 төсөл, арга хэмжээний 234 багцын тендер шалгаруулалтыг зохион байгуулсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан 8 зорилтын хүрээнд 55 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж ажилласнаас биелэлт 95.1 хувийн гүйцэтгэлтэйгээр тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

Z:\Yawsan_Bichig\2024\0223 SNAG-134 Docx

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **7,011,900.00** | **10,615,980.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **7,011,900.00** | **10,615,980.00** |
| **35400** | **Хангамжийн материал** | **7,011,900.00** | **10,615,980.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 6,008,400.00 | 9,936,980.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,003,500.00 | 679,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,841,489,850.14** | **2,125,600,057.43** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,841,489,850.14** | **2,125,600,057.43** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **395,277,850.14** | **652,325,297.43** |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 1,731,911,141.90 | 1,273,667,767.14 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (1,386,232,052.12) | (676,574,907.14) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 140,463,423.20 | 128,334,784.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (90,864,662.84) | (73,102,347.07) |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **1,446,212,000.00** | **1,473,274,760.00** |
| 39301 | Программ хангамж | 37,955,280.00 | 27,062,760.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (37,955,280.00) | 0.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,446,212,000.00 | 1,446,212,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,848,501,750.14** | **2,136,216,037.43** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,848,501,750.14** | **2,136,216,037.43** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,848,501,750.14** | **2,136,216,037.43** |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **1,848,501,750.14** | **2,136,216,037.43** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 617,645,227,881.83 | 1,848,501,750.14 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (615,796,726,131.69) | 287,714,287.29 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,848,501,750.14** | **2,136,216,037.43** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **1,473,731,817.56** | **2,568,290,488.16** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **24,565,500.00** | **463,413,816.44** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **24,565,500.00** | **463,413,816.44** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **24,565,500.00** | **463,413,816.44** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 19,315,500.00 | 106,692,910.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 5,250,000.00 | 356,720,906.44 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,449,166,317.56** | **2,104,876,671.72** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **965,868,800.00** | **1,407,418,800.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 965,868,800.00 | 1,407,418,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **483,297,517.56** | **697,457,871.72** |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 483,297,517.56 | 697,457,871.72 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **14,355,454,395.49** | **2,280,576,200.87** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **14,355,454,395.49** | **2,280,576,200.87** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,535,224,505.80** | **1,592,419,356.40** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **728,046,794.34** | **884,544,557.09** |
| 210101 | Үндсэн цалин | 499,986,360.67 | 537,024,680.12 |
| 210102 | Нэмэгдэл | 102,752,565.08 | 156,207,084.81 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 70,735,374.33 | 120,596,273.30 |
| 210104 | Урамшуулал | 54,572,494.26 | 70,716,518.86 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **90,417,400.00** | **114,367,622.79** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 60,996,233.05 | 78,358,851.51 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,689,415.32 | 9,212,717.79 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,795,133.78 | 7,145,654.21 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,448,783.40 | 1,786,563.58 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,487,834.45 | 17,863,835.70 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **115,010,000.00** | **165,899,990.00** |
| 210304 | Байрны түрээс | 115,010,000.00 | 165,899,990.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **22,178,326.00** | **11,468,225.37** |
| 210401 | Бичиг хэрэг | 7,810,580.00 | 2,892,010.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 981,200.00 | 0.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 11,196,321.00 | 7,836,715.37 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,190,225.00 | 739,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **51,116,926.00** | **62,105,602.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 933,000.00 | 34,405,560.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 89,100.00 | 0.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 0.00 | 69,776.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 50,094,826.00 | 27,630,266.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **528,455,059.46** | **354,033,359.15** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 0.00 | 80,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 528,455,059.46 | 353,953,359.15 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **12,820,229,889.69** | **688,156,844.47** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **12,397,795,198.47** | **0.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 12,397,795,198.47 | 0.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **0.00** | **198,421,500.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.00 | 30,721,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 0.00 | 167,700,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **422,434,691.22** | **489,735,344.47** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 24,197,279.66 | 117,594,398.75 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 398,237,411.56 | 372,140,945.72 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН** | **(12,881,722,577.93)** | **287,714,287.29** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН** | **(615,796,726,131.69)** | **287,714,287.29** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **1,468,481,817.56** | **2,211,569,581.72** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **19,315,500.00** | **106,692,910.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **19,315,500.00** | **106,692,910.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **19,315,500.00** | **106,692,910.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 19,315,500.00 | 106,692,910.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,449,166,317.56** | **2,104,876,671.72** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **965,868,800.00** | **1,407,418,800.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 965,868,800.00 | 1,407,418,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **483,297,517.56** | **697,457,871.72** |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 483,297,517.56 | 697,457,871.72 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **13,828,311,736.03** | **1,930,226,921.72** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **13,828,311,736.03** | **1,930,226,921.72** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,008,081,846.34** | **1,242,070,077.25** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **728,046,794.34** | **884,544,557.09** |
| 210101 | Үндсэн цалин | 499,986,360.67 | 537,024,680.12 |
| 210102 | Нэмэгдэл | 102,752,565.08 | 156,207,084.81 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 70,735,374.33 | 120,596,273.30 |
| 210104 | Урамшуулал | 54,572,494.26 | 70,716,518.86 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **90,417,400.00** | **114,367,622.79** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 60,996,233.05 | 78,358,851.51 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,689,415.32 | 9,212,717.79 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,795,133.78 | 7,145,654.21 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,448,783.40 | 1,786,563.58 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,487,834.45 | 17,863,835.70 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **115,010,000.00** | **165,899,990.00** |
| 210304 | Байрны түрээс | 115,010,000.00 | 165,899,990.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **23,490,726.00** | **15,072,305.37** |
| 210401 | Бичиг хэрэг | 7,635,480.00 | 6,820,590.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,995,200.00 | 0.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 11,196,321.00 | 7,836,715.37 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,663,725.00 | 415,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **51,116,926.00** | **62,105,602.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 933,000.00 | 34,405,560.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 89,100.00 | 0.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 0.00 | 69,776.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 50,094,826.00 | 27,630,266.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **0.00** | **80,000.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 0.00 | 80,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **12,820,229,889.69** | **688,156,844.47** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **12,397,795,198.47** | **0.00** |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 12,397,795,198.47 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **0.00** | **198,421,500.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.00 | 30,721,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 0.00 | 167,700,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **422,434,691.22** | **489,735,344.47** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 24,197,279.66 | 117,594,398.75 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 398,237,411.56 | 372,140,945.72 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(12,359,829,918.47)** | **281,342,660.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **37,965,280.00** | **281,342,660.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **37,965,280.00** | **281,342,660.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **37,965,280.00** | **281,342,660.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 37,965,280.00 | 281,342,660.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(37,965,280.00)** | **(281,342,660.00)** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 12,397,795,198.47 | 0.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **617,645,227,881.83** | **617,645,227,881.83** |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **617,645,227,881.83** | **617,645,227,881.83** |
| **9** | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | (615,796,726,131.69) | (615,796,726,131.69) |
| **10** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **1,848,501,750.14** | **1,848,501,750.14** |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **1,848,501,750.14** | **1,848,501,750.14** |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 287,714,287.29 | 287,714,287.29 |
| **20** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **2,136,216,037.43** | **2,136,216,037.43** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,427,418,800.00** | **1,396,517,311.25** | **30,901,488.75** | **97.8** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,427,418,800.00** | **1,396,517,311.25** | **30,901,488.75** | **97.8** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,228,997,300.00** | **1,198,095,811.25** | **30,901,488.75** | **97.5** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **893,958,000.00** | **884,544,557.09** | **9,413,442.91** | **98.9** |
| 210101 | Үндсэн цалин | 550,758,900.00 | 537,024,680.12 | 13,734,219.88 | 97.5 |
| 210102 | Нэмэгдэл | 252,876,000.00 | 156,207,084.81 | 96,668,915.19 | 61.8 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 51,975,000.00 | 120,596,273.30 | (68,621,273.30) | 232.0 |
| 210104 | Урамшуулал | 38,348,100.00 | 70,716,518.86 | (32,368,418.86) | 184.4 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **132,707,400.00** | **114,367,622.79** | **18,339,777.21** | **86.2** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 90,240,900.00 | 78,358,851.51 | 11,882,048.49 | 86.8 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,616,700.00 | 9,212,717.79 | 1,403,982.21 | 86.8 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,493,200.00 | 7,145,654.21 | 1,347,545.79 | 84.1 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,123,400.00 | 1,786,563.58 | 336,836.42 | 84.1 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,233,200.00 | 17,863,835.70 | 3,369,364.30 | 84.1 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **165,955,500.00** | **165,899,990.00** | **55,510.00** | **100.0** |
| 210304 | Байрны түрээс | 165,955,500.00 | 165,899,990.00 | 55,510.00 | 100.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **15,078,800.00** | **15,072,305.37** | **6,494.63** | **100.0** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,550,200.00 | 6,820,590.00 | (3,270,390.00) | 192.1 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,281,900.00 | 0.00 | 1,281,899.99 | 0.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8,843,600.00 | 7,836,715.37 | 1,006,884.63 | 88.6 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,403,100.00 | 415,000.00 | 988,100.00 | 29.6 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **21,181,400.00** | **18,131,336.00** | **3,050,064.00** | **85.6** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 17,440,000.00 | 14,425,560.00 | 3,014,440.00 | 82.7 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 69,800.00 | 69,776.00 | 24.00 | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 13,700.00 | 0.00 | 13,699.99 | 0.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,657,900.00 | 3,636,000.00 | 21,900.00 | 99.4 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **116,200.00** | **80,000.00** | **36,200.00** | **68.8** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 116,200.00 | 80,000.00 | 36,200.00 | 68.8 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **198,421,500.00** | **198,421,500.00** | **0.00** | **100.0** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **198,421,500.00** | **198,421,500.00** | **0.00** | **100.0** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 30,721,500.00 | 30,721,500.00 | 0.00 | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 167,700,000.00 | 167,700,000.00 | 0.00 | 100.0 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,427,418,800.00** | **1,396,517,311.25** | **30,901,488.75** | **97.8** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,407,418,800.00** | **1,289,824,401.25** | **117,594,398.75** | **97.8** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,407,418,800.00 | 1,289,824,401.25 | 117,594,398.75 | 97.8 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **20,000,000.00** | **106,692,910.00** | **(86,692,910.00)** | **533.5** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 20,000,000.00 | 106,692,910.00 | -86,692,910.00 | 533.5 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **1** | **1** | 0.00 | 100.0 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** | 0.00 | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | 0.00 | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **54** | **38** | 0.00 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 0.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 49 | 29 | 0.00 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 4 | 8 | 0.00 | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **697,457,871.72** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **416,115,211.72** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **43,974,266.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **43,974,266.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 19,980,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 23,994,266.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **372,140,945.72** |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **372,140,945.72** |
| 213305 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 372,140,945.72 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **281,342,660.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | | **281,342,660.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 281,342,660.00 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | **697,457,871.72** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **697,457,871.72** |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 697,457,871.72 |

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 167.7 сая төгрөгийн зөрчил[2] илэрч албан шаардлага хүргүүлсэн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| д/д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Нэр бүхий 39 ажилтан, албан хаагч нарт 2023 оны 12 дугаар сард 167,700.0 мянган төгрөгийн тусламж, тэтгэмжийг хавтгайруулан олгосон. | 1 | 167,700.0 | 1 | 167,700.0 | | |
| | **Дүн** | **1** | **167,700.0** | **1** | **167,700.0** | | |